



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

“Тэнгэр даатгал” ХХК-ийн
хувь нийлүүлэгчдийн бүтцэд өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тэнгэр даатгал” ХХК-ийн гаргасан 1,000 /нэг мянган/ ширхэг хувьцааг худалдах, худалдан авах гэрээг байгуулахыг “Тэнгэр даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгч “Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК болон “Петровис” ХХК-иудад зөвшөөрч, хувь нийлүүлэгчдийн бүтцэд дараахь байдлаар өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1.	“Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК	1,000,000,000.0	1,000,000,000.0	2,000,000,000.0	100%
2.	“Петровис” ХХК	1,000,000,000.0	(1,000,000,000.0)	0.0	0%
	Нийт	2,000,000,000.0		2,000,000,000.0	100%

2. Хувь нийлүүлэгчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Тэнгэр даатгал” ХХК /Г.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

00047